



СЭЛЭНГЭ АЙМАГ  
БАЯНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/235

Баруун хараа

Золбин нохой, муур устгах ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх заалт, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 01 тоот албан даалгаварыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирусийн халдвар /COVID-19/-ын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор тус сумын нутаг дэвсгэрт золбин нохой, муур устгах ажлыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдрийг дуустал зохион байгуулж ажиллахыг багийн Засаг дарга (Р.Сэлэнгэ, Д.Цэрэндулам, А.Бадамцэцэг) нарт даалгасугай.

2. Төр төсвийн байгууллага, аж ахуй нэгжүүд өөрсдийн эзэмшлийн талбай, талбайн орчимд устгагдсан золбин нохой, муурны ариутгал, халваргүйтгэлийг хийж ажиллахыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт, нийтийн эзэмшлийн талбайд устгагдсан золбин нохой, муурны ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж ажиллахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд (Ч.Даваадорж, Н.Эрдэнэбат, Б.Жаргалсайхан)-д даалгасугай.

3. Золбин нохой, муурын устгал явагдаж байгаатай холбогдуулан гэрийн тэжээвэр амьтад болон хоточ нохой, муурыг байнга уяатай байлгахыг нийт иргэд, аж ахуйн нэгж байгууллагад даалгасугай.

4. Золбин нохой, муурын устгалын ажлын гүйцэтгэл, ариутгал халдваргүйтгэлийн ажилд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (М.Бумцэнд), мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (Х.Уянга) нарт үүрэг болгосугай.

5. Золбин нохой, муурын устгалын ажилд шаардагдах зардлыг тооцож, Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү албаны дарга (Г.Баясгалан), захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Эрдэнэбаатар) нарт үүрэг болгосугай.



Р.БАТЖАРГАЛ